



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 0/337

Улаанбаатар хот

### “Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэгийн” эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,278,390.00 (долоон сая хоёр зуун далан найман мянга гурван зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг (Б.Түмэнжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 10 нэр төрлийн 3,640,390.00 (гурван сая зургаан зуун дөчин мянга гурван зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн, устгах, 3 нэр төрлийн 3,638,000.00 (гурван сая зургаан зуун гучин найман мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 60,000.00 (жаран мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 18,000.00 (арван найман мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг (Б.Түмэнжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1050501051

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 138 дугаар сарын 13-ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан	Хэмжээ	ТОО	Хэмжээ	Нэргийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Тоос сорогч	10	ш	2	450,000.0	900,000.0	900,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
2	Будаа агшаагч	8	ш	1	34,000.0	34,000.0	34,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
3	Нотебуук Asus	10	ш	1	950,000.0	950,000.0	950,000.0	0.00	0.00	ашиглалтын шаардлага хангахгүй	актлах	устгах	20,000	20,000
4	Принтер /1 үйлдэлтэй/	10	ш	1	220,000.0	220,000.0	220,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
5	Хоолны тогоо /1-р /	10	ш	1	2,200,000.0	2,200,000.0	2,200,000.0	0.00	0.00		актлах	устгах	20,000	20,000
6	Жигнүүр 280	10	ш	1	600,000.0	600,000.0	600,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
7	Компьютер цагаан	10	ш	1	488,000.0	488,000.0	488,000.0	0.00	0.00		актлах	устгах	20,000	20,000
Машин тоног төхөөрөмжийн дүн				8	4,942,000.0	5,392,000.0	5,392,000.0	0	0					
Тавилга эд хогшил														
8	хүүхдийн сандал-1	10	ш	2	12,000.0	24,000.0	24,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
9	хүүхдийн сандал-2	10	ш	3	14,250.0	42,750.0	42,750.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
10	хүүхдийн сандал-3	10	ш	5	11,000.0	55,000.0	55,000.0	0.00	0.00	ашиглалтын шаардлага хангахгүй	актлах	устгах	устгах	устгах
11	хүүхдийн сандал-4	10	ш	26	13,640.0	354,640.0	354,640.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
12	хүүхдийн сандал-5	10	ш	12	21,250.0	255,000.0	255,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
Тавилга эд хогшилын дүн				48	72,140.0	731,390.0	731,390.0							
Биет бус хөрөнгө														
13	Ассюлс 3.5 программ	6	ш	1	1,155,000.0	1,155,000.0	1,155,000.0	0.00	0.00		актлах	устгах	устгах	устгах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				57	5,014,140.0	7,278,390.0	7,278,390.0	-	-					
Үүнээс Худалдах хөрөнгө				3	3,638,000.0									3
Устгах хөрөнгө				54	3,640,390.0									10
Худалданаас олох орлого													60,000	60,000.00
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/													18,000	18,000.00